



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 619

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 7,081,000.00 (долоон сая наян нэгэн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Банзрагч нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА



0000007

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн
649 дугаар тогтоолын хавсралт

"Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн/ ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	"КИА Пронтер", 57-86 УБД, суудлын, KRHYAC3A2B030581	2002/2013	275000	7,081,000.00	7,081,000.00	0.00	0	2,500,000.00
	Нийт дүн			7,081,000.00 (долоон сая наян нэгэн мянган)	7,081,000.00 (долоон сая наян нэгэн мянган)	-	-	2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган)